



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/36

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Улсын Их Хурлын 2022 оны 80 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн “Дэмжлэг үзүүлж ажиллах тухай” ХЭГ/272 тоот албан бичгийн дагуу улс орны нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн тусламжтайгаар тодорхойлох, иргэдтэй зөвлөлдөх санал асуулгыг орон нутагт зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг хавсралтаар байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүдэд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Цагдаагийн газрын дарга

Онцгой байдлын газрын дарга

Эрүүл мэндийн газрын дарга

Алаг-Эрдэнэ сумын Засаг дарга

Галт сумын Засаг дарга

Рэнчинлхүмбэ сумын Засаг дарга

Түнэл сумын Засаг дарга

Цэцэрлэг сумын Засаг дарга

Мөрөн сумын Засаг дарга

Нарийн бичгийн дарга: Статистикийн хэлтсийн дарга

2. Зөвлөлдөх санал асуулгын судалгааны ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгосугай.

3. Ажлын хэсгийг мэдээллээр хангаж ажиллахыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (Б.Базардамбуу)-д даалгасугай.

ОРЛОГЧ

М.ХУЯГБААТАР

6712010107